



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот


┌ Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.9, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4, 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөлөл Ц.Уртнасанг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны гишүүн О.Батмөнхийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн гишүүнээр томилсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

1518900530